

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

**НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД
б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:**

9 дүгээр сарын 14 ны өдөр Гамшгийн үеийн бэлэн байдлын үзлэг шалгалтыг зохион байгуулан ажиллав. Үзлэг шалгалтад мэргэжилийн ангийн 60 албан хаагч хамрагдаж бэлэн байдлаа шалгуулан ажиллав.

Е- Mongolia: Цахим системээс Иргэний үнэмлэхийн лавлагаа – 4, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа - 2, жолооны үнэмлэхийн лавлагаа-2, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт – 15, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа – 5, НАХЯ-ны хилийн ба дотоодын цэрэгт цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа - 0 , нийт - 28 лавлагаа олголоо.

Пэйж хуудсанд энэ сар нийт 15 пост(мэдээ мэдээлэл) оруулсан. Халзан сумын албан ёсны вэб сайт болох Khalzan.su.gov.mn хандах эрхийг олж авч веб сайтны хөгжүүлэлт болон нэмэх зүйл дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн өөрчлөлт, төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн орууллаа.

9-р дүгээр сард нийт ирсэн бичиг 15, хариутай -7, үүнээс хугацаанд нь илгээсэн -6, хугацаа болоогүй -1, явсан бичиг -12 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

9 дүгээр сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 85.0 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 102.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулж байгаа “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-нд хөдөөгийн Сайншандны 3 дугаар баг сонгогдож, газрын зурагт багтсан 102 өрхийн тодруулгыг хийж аймгийн статистикийн хэлтэст хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтанд амжилттай шалгууллаа.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

2023 оны 9 сарын 22 ны өдөр эрүүл амьдрал зөв хоололт амьдралын зөв хэв маяг сэдвээр нийгмийн эрүүл мэндийн ажилтан мэдээлэл хийж ажиллав.

Хүүхэд хөгжлийн жил болгон зарласантай холбогдуулан хүүхэд хамгааллын тухай хууль болон хүүхдийн эрх чиглэлээр сургууль цэцэрлэгийн багш ажилчдад сургалт зохион байгуулан ажиллалаа.

**ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Боловсролын чиглэлээр: 09-р сарын 1-ны өдөр хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, ауб нар ангиуддаа “эх хэлний талаархи хичээлийг заасан.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалт ,үйл ажиллагааг зохион байгуулахад 2023-2024 оны хичээлийн жилд баримтлах чиглэлийн дагуу 1-р ангийн сурагчдыг эрүүл

мэндийн урьдчилан сэргийлэлт , эрт илрүүлэг үзлэгийг сургуульд суурилан, сумын эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн нийтийн номын сангаас зохион явуулсан "эх хэл-бидний бахархал" цахим шүлгийн уралдаанд 5а ангийн сурагч у.түвшинсайхан чойномын " монгол " шүлгээр оролцож дэд байр эзэлсэн амжилттай байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг алтан намар-2023 спартикад 6 төрлөөр зохион байгуулагдлаа. Тус спартакиад нь: 100, 400, 800метрийн гүйлт /эрэгтэй , эмэгтэй/, уртын харайлт /эрэгтэй, эмэгтэй/, бөөрөнцөг шидэлт, буухиа гүйлт гэсэн төрлүүдээр 1-9 р ангийн суралцагчдын дунд зохион байгуулагдаж спортын аваргуудаа тодрууллаа.

Pearson хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 5-6р ангийн сурагчдад англи номоор үзэсгэлэн гаргалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдын сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээ зохион байгуулах журмын дагуу 3дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна.

2023-2024 оны хичээлийн жилд 1 дүгээр ангийн 26 сурагч хамрагдахаар системд нэрс бүртгэгдсэний дагуу 2023.09.13-ны өдрөөс эхлэн хийгдэж байна.

Соёлын чиглэлээр: Номын сангаар үйлчлүүлсэн уншигч тоо- 116

Соёлын төвийн Номын сан нь шинээр номоо данслах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. libu4 программд 206,109 төгрөгийн үнэ бүхий нийт 586 ш номыг цахим программд оруулан ажиллаж байна.

Эх хэлний өдөр буюу 9 сарын 1-нд зохион байгуулсан СОН үйл ажиллагаа

Номын сангийн зочны ярилцлага: “Эргэн дурсахуй” уулзалт ярилцлага Монгол хэл уранзохиолын ахмад багш С.Ганболд оролцлоо. Ярилцлаганд ЕБС-ийн 9 дүгээр ангийн 15 сурагч хамрагдлаа.

“Алтан хонх” танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн оролцогчдын тоо-27 сурагч

“Эх хэлээ эрхэмлэн дээдлэе” бүх анги урилга дэвшүүллээ оролцогчдын тоо- 203

“Эх хэл - бичиг соёл” Монгол хэл, уранзохиолын багш Д.Гэрэлтуяагийн хичээлийн хэрэглэгдэхүүн гарын авлагаар үзэсгэлэн гаргалаа. Үзэсгэлэнд хамрагсдын тоо- 56

Үндэсний номын баярыг угтан зохион байгуулсан СОН үйл ажиллагаа:

“Танд ойрхон- номын сан” ЕБС-ийн сурагчдын дотуур байранд зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

46ш ном үйлчилгээнд гаргаж 20 сурагчдад уншигчийн карт нээж ажилласан байна.

“Өнгөрснийг өнөөдөр дурсахуй” 50,60,70 оны яруу найраг зохиолын номоор үзэсгэлэн гаргалаа. Үзэсгэлэнд 56 нэр төрлийн ном дэлгэгджээ.

“OPEN-MIC” яруу найргийн нээлттэй микрофон зохион байгуулж хуучны яруу найргийн номноос ЕБС-ийн 9 сурагч уншиж сонордууллаа.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын татан авалтыг хийж 4 багийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 26,700 хурганд хийх 170, 153,169 серийн дугаартай 100 тунтай 26700 тун вакциныг 4 аж ахуй нэгжид хувиарлаад байна. Нийт 36 өрхийн 1650 хурга хамрагдаад байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 35907 охин төл хамрагдана.
REV-1 33476, Штам-19 2431 тун вакцин татан авч хувиар хийгээд байна.

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 02 тоот албан даалгаварын биелэлтийг гаргаж аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэв.

Нийт 5 шонхорын гэрээ байгуулан ажиллав.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

М.ХУЯГ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДАЙРИЙМАА